

Тоонууд сонгох

Өгөгдсөн тоон дарааллаас аль ч 2 тооных нь абсолют ялгавар 1-ээс бага буюу тэнцүү байх хамгийн ихдээ хэдэн тоо сонгон авч болох вэ?

Жишээлбэл

{1,1,2,2,4,4,5,5,5} гэсэн тоон дарааллаас нөхцөлийг хангахаар дараах 2 байдлаар тоонуудыг сонгон авч болно.

{1,1,2,2} {4,4,5,5,5}. Эхнийх нь 4 тоотой, дараагийнх нь 5 тоотой тул 5-ыг хэвлэнэ.

Оролт

Дарааллын урт n шинэ мөрөнд өгөгдөнө. $2 \leq n \leq 100$.

n ширхэг тоо зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. $0 <$ дарааллын гишүүн < 100 .

Гаралт

Нөхцөлийг хангах хамгийн их тоотой дэд олонлогийн урт. Хариу ямагт 2-оос их байхаар өгөгдөл өгөгдөнө.

Жишээ

Оролт 1

6

4 6 5 3 3 1

Гаралт 1

3

Тайлбар 1

{4, 3, 3} олонлогийг сонгоно.

Оролт 2

6

1 2 2 3 1 2

Гаралт 2

5

Тайлбар 2

{1, 1, 2, 2, 2} олонлогийг сонгоно.